



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Стандарт, Хэмжилзүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс аудит” ХХК Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
--	----------	------------	------------



Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	5.8	10.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	217.4	243.1
	Нийт хөрөнгийн дүн	223.2	253.2
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	223.2	253.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	223.2	253.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	325.0	324
	Үйл ажиллагааны зардлын дүн	272.8	291.2
	Үйл ажиллагааны үр дүн	52.2	32.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	(1.3)	-2.7
	Үйл ажиллагааны нийт үр дүн	50.9	30.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	183.8	183.8
	Тайлант оны үр дүн	39.3	69.4
	Эцсийн үлдэгдэл	223.1	253.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	257.9	275.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	255.9	263.5
	Үйл ажиллагааны ЦМГ	2.0	12.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		-12.1
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	2.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	192.8	185.8
	Урсгал зардал	192.8	185.8
	Хөрөнгийн зардал	-	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	117.8	110.8
	Улсын төсвөөс санхүүжих	117.8	110.8
	Орон нутгийн төсвөөс		
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	75.0	75

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа



Өмнөговь аймгийн Стандарт, Хэмжилзүйн хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Аймаг, орон нутгийн эдийн засаг нийгмийн амьдралд стандартчилал, хэмжилзүй, баталгаажуулалтын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлж, бүтээгдхүүн, ажил үйлчилгээг дэмжих, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, аюулгүй байдлыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллана” гэж тодорхойлсон байна.

- Дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд 29 арга хэмжээ төлөвлөжээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ковид цар тахалтай холбоотойгоор 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан орон нутагт хийгдэх баталгаажуулалтын ажил хойшлогдсон байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөговь аймгийн Стандарт, Хэмжилзүйн хэлтэс 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Аймаг, орон нутгийн эдийн засаг нийгмийн амьдралд стандартчилал, хэмжилзүй, баталгаажуулалтын үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлж, бүтээгдхүүн, ажил үйлчилгээг дэмжих, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, аюулгүй байдлыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллана” гэсэн зорилтын хүрээнд 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.9 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 269,128.3 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс 14,602.9 мянган төгрөгийн санхүүгийн тайлагнал, бүртгэлтэй холбоотой 2 алдааг залруулж, өмнөх аудитын зөвлөмжтэй холбоотой зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 255,905.4 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Санхүүгийн тайлангийн аудитаар											
	Мөнгөн гүйлгээний тайлан дахь эд	1	12,108.8	1	12,108.8						



	Холшил, урсгал засварын зардлын данснаас худалдан авч бэлтгэсэн үндсэн хөрөнгийг хөрөнгийн зардлаар бүртгэж, тайлагнаагүй											
3	Э баримт цахим төлбөрийн системд тайлант оны үйлчилгээний орлогыг цахим бүртгэлийн системд шивээгүй байна.	1	109,333.3						1	109,333.3		
4	Холбогдох эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэргүйгээр бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан	1	1,989.7						1	1,989.7		
5	Санхүүгийн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны зардлыг үйл ажилллагааны зардлаар тайлагнасан	1	2,494.1	1	2,494.1							
6	Говийн дэм хөтөлбөрөөс олгосон 1,647.5 мянган төгрөгийн урамшууллын зардлаас ХХОАТ суутгаж, Татварт шилүжүүлсэн боловч татварын тайланд тусгаагүй	1	1,647.5						1	1,647.5		
7	Үйл ажиллагааны давсан орлогоос албан хаагчдад олгосон нэг удаагийн тэтгэмж урамшууллаас НДШ, ХХОАТ суутган тооцоогүй	1	17,000.0						1	17,000.0		
	Дүн	6	144,574.5	2	14,602.9				1	-	6	129,970.5